

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2023 оны хоёрдугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Газрын даргын 01/09-03 дугаар удирдамжийн дагуу дотоод аудит хийж гүйцэтгэв.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээлэл агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг хангаж байх, мэдээллийн үр дүнд анхаарч ажиллах дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

1.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;

2.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тушаалыг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

3.Дотоод аудитын зөвлөмж, удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэл, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.Байгууллага оруулах тайлан буюу Хавсралт файлуудыг бүрэн мэдээлэх;

5.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг мэдээлэх.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан, түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

--ооОоо--